

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ОРХОН АЙМАГТ ХИЙГДСЭН АЖИЛ-аас

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй УИХ-ын 36 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулан, 23 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг тусган ажиллаж байна.

Хүнсний хангамж

2025 оны жилийн эцсийн байдлаар хүнсний 123 үйлдвэр 44.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 51.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийж, 2900 мянган тн мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн 428.0 мян.л, гурилан бүтээгдэхүүн 3000 тн, төмс 2.2 мянган тн, хүнсний ногоо 11.6 мянган тн, өндөг 99.3 тн үйлдвэрлэн 2460.4 тн үхэр, адуу, хонины махыг Иран, Казакстан, ОХУ-д экспортлосон. Аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 78.8 хувь, сүүний 8.5 хувь, цагаан идээний 7.6 хувь, гурилан бүтээгдэхүүний 53.6 хувь, төмсний 60.4 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгийн 15 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна.

Олгогдсон зээл

2022-2025 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 24 аж ахуйн нэгжид 3.6 тэрбум, УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний чиглэлийн 18 аж ахуйн нэгжид 4.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Атар-4 тариалангийн тогтвортой аяны хүрээнд 20 иргэн, аж ахуйн нэгж 7.5 тэрбум төгрөг, Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд 1 аж ахуйн нэгж 188.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 49 иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд 1.6 тэрбум төгрөг, "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний хүрээнд 47 хоршооны 174 малчин өрхөд 6.4 тэрбум, нийт 159 иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд 23.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Ингэснээр 105 ажлын байр шинээр бий болж 168 ажлын байр хадгалагдсан.

Газар тариалангийн салбарт:

Төмс, хүнсний ногооны механикжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Жаргалант сумын "Агро үйлчилгээний дундын төв"-ийн трактор, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар тус төвд дунд оврын трактор 6, бага оврын трактор 2, анжис, борной, ургамал хамгааллын бодис шүршигч, бууц, үрлэн бордоо цацагч, төмс, хүнсний ногооны үрлэгч, төмсний копатель, мотоблок, бүх төрлийн үрслэг суулгагч, мөр хоорондын сийрүүлэгч, хадуур тармуур, хаман боогч зэргийг ашиглаж Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан үнэ тарифын дагуу иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Энэ онд давхардсан тоогоор 439 иргэн, аж ахуйн нэгжид 14 төрлийн үйлчилгээ үзүүлсэн.

2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3.4 тэрбум төгрөгөөр 500 тн-ын багтаамжтай зоорь барьж ашиглалтад оруулсан нь төмс, хүнсний ногооны стандартын шаардлага хангасан, механикжсан зоорины багтаамж 500 тн-оор нэмэгдсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс “Бүтлийн ундарга” ХХК-ийн улаан буудайн 3000 тонны багтаамжтай агуулахын барилга, байгууламж барих зориулалтаар 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авснаар улаан буудайн агуулах 3000 тн-оор нэмэгдэж, нийт агуулахын хэмжээ 10 буюу 6640 тн-д хүрсэн. Мөн хүнсний бөөний худалдааны “Олон гурил” ХХК 400.0 сая, жимсний бөөний худалдааны “Заяа сор” ХХК 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авснаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний агуулахын хэмжээ 130 тн-оор, жимсний тоноглогдсон хөргүүр 1-ээр, том оврын хүнсний тээврийн хэрэгсэл 2-оор нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 223 иргэн, 6 аж ахуйн нэгж 37.8 мян.м.кв хүлэмжийн талбайд тариалалт эрхэлж 439,6 тн ургац хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургац 4 хувь эзэлж байна.

Төмс, хүнсний ногооны талбайд усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор “Шинэ хөдөө-Орхон” төслийн хүрээнд 2023, 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 210.2 сая төгрөгийн үнэ бүхий 16 ширхэг 1 га талбай услах хүчин чадалтай бороожуулах услалтын системийг сонгон шалгаруулалтаар 14 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр эзэмшүүлсэн. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээ 20 га талбайгаар нэмэгдсэн. Тус ажилд улсын төсвөөс 2023 онд 180.0 сая, 2024 онд 30.2 сая төгрөг зарцуулсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд услалтын системийг шинэчлэн сайжруулах төслийн 2 дугаар шатанд Хангал голын дагуу төмс, хүнсний ногооны 700 га талбайн усалгааны нөхцөл сайжруулахаар шийдвэрлэж төслийн ажлын даалгавар, зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байна.

Мал аж ахуйн салбарт:

Аймгийн хэмжээнд 29 багийн 1102 малчин өрхөд 187.8 мянган толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 525.2 мянган толгой мал хаваржиж байна. Нийт мал сүргийн 34.9 хувь буюу 61.4 мянган толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан. 2024 онд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах 55.4 хувь байсан бол 2025 онд хөдөө аж ахуйгаас 2966.3 тонн мах бэлтгэсний 1817.3 тонн буюу 61.2 хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна.

2022-2025 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Барга үүлдрийн хуц 60 толгой, Эрчимийн хар үүлдрийн ухна 40 толгой, Герефорд үүлдрийн бух 15 толгой, нийт 115 толгой өсвөр хээлтүүлэгчийг худалдан авч малчдад түрээсээр ашиглуулж байна.

Аймгийн хэмжээнд жилд 275 тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай 6 тэжээлийн үйлдвэр ажиллаж байна. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд “Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо”-нд ногоон тэжээл боох тоног төхөөрөмж, худалдан авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Прогресс төслөөс 7.0 сая, нийт 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Тахианы аж ахуйн эрхлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мал нядалгаа, бордооны үйлдвэрийн эрхлэх, мах, сүүний чиглэлийн фермер эрхлэх зэрэг зориулалтаар 5 малчдын хоршоонд 23.13 га газар эзэмшүүлсэн байна.

Стандарт, хэмжил зүйн салбарт:

2023–2025 онд тохирлын баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүлэн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын тогтолцоо, зохистой дадлыг үе шаттайгаар нэвтрүүлж, баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хамрах хүрээг тогтвортой нэмэгдүүлсэн. Энэ хугацаанд баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээний эзлэх хувь 82.5 хувиас 85.6 хувь болж нэмэгдсэн бөгөөд өссөн дүнгээр 533 цэг тохирлын баталгаатайгаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, үүнээс 351 буюу 57.9 хувь нь стандартын шаардлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлж байна.

Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх чиглэлээр 2024 оноос Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний 8 үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлснээр тогтолцоо хэрэгжүүлсэн байгууллагыг 3 дахин нэмэгдүүлж нийт 12 үйлдвэрлэлд хэрэгжүүлж байна. Үүнээс 6 байгууллага гэрчилгээжсэн, 1 байгууллага гэрчилгээжих шатанд, 1 байгууллага аудитын шатанд, 4 байгууллага хэрэгжилтийн дараах хяналтын шатанд ажиллаж байна.

Мөн MNS 7005:2023 стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд ерөнхий боловсролын 22 сургуулийн 26 хоол үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, зохистой дадлыг хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 35 ажилтныг сургалтад хамруулан чадавхжуулсан.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хими, нян судлалын лаборатори нь итгэмжлэлийн дагуу 79 нэр төрлийн бүтээгдэхүүнд 508 үзүүлэлтээр хими, хор судлал, нян судлалын шинжилгээ хийхээр 4 жилийн хугацаатайгаар итгэмжлэгдсэн. Шинжилгээний үр дүнгийн үнэн бодит байдлыг хангах, нарийвчлалыг нэмэгдүүлэх зорилгоор лабораторид 541.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Мал эмнэлгийн салбарт:

2023 онд Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар малын үзлэг, угаалгын зөөврийн 4 хашаа, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн 19.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар вакцин тарилгын суурийн хашаа барьж ашиглалтад оруулсан. 2024 онд Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн 65.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мал угаалгын банн барьж ашиглалтад оруулсан бөгөөд Мал эмнэлгийн үйлчилгээний 8 нэгж, стандартын шаардлагыг 100 хувьтай хангасан. 2025 онд Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар малын угаалгын 3 тоног төхөөрөмжийг олгосон. Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн 49 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мал угаалгын суурин банн барьж ашиглалтад оруулсан. Үүний дүнд 2025 онд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн үйлчилгээний 5 нэгж 100 хувь стандарт шаардлагыг ханган ажилласан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Жаргалант суманд мод үржүүлгийн зориулалтаар 1 байршилд 2.99 га талбай эзэмшүүлсэн. Жаргалантын аманд байршилтай тариалангийн 6.5 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөснөөс 664.85 м урттай хашааг барьж ашиглалтад оруулж 3.6 км хашаа шинээр, 1.5 км хашааг сэргээн засварласан. Нийт тариалангийн талбайн ойн зурвас байгуулахаар 5.9 км талбайг хашиж хамгаалсан.

Баян-Өндөр сум мод үржүүлгийн чиглэлээр 19 га газрыг 10 иргэн, 9 аж ахуйн нэгжид олгосон. Үүнээс “Зэс эрдэнийн хувь” ХХК 2 га, 2 иргэн 2 га талбайд үйл ажиллагаа эхлүүлж, улиас, хайлаас, бургасыг үржүүлж нийт 0.45 га талбайд 1170 ширхэг суулгацын тариалалт хийсэн. “Хантөгөл хайлаас” ХХК, “Алтан үрслэг” ХХК нь 10 га төмс, хүнсний ногооны талбайг хамгаалсан 300 метр урттай ойн зурвас, “Далайн хошууны шинэс” ХХК газар тариалангийн ойн зурваст 400 метр урттай ойн зурвас, нийт 700 метр урт газар тариалангийн хамгаалалтын ойн зурвас байгуулсан байна.

Сургалт зохион байгуулах, мэргэшилтэй боловсон хүчин бэлтгэх:

Хөдөө аж ахуйн болон Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвд 1-2.5 жилийн сургалтаар мэргэжилтэй ажилтан бэлтгэж тракторын механик 18, хүлэмжийн аж ахуйн фермер 46, ойжуулагч 48, талх, нарийн боовчин 37, тогооч мэргэжлээр 73, нийт 222 суралцагч төгссөн. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 1400 /давхардсан тоогоор/ иргэнийг 21 удаагийн мэргэжлийн сургалтад хамруулсан байна.

-00-00-